

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

Залбирлаар дамжуулан Бурхантай харилцах нь

Далын Ахлагч Сиү Хонг Пон

Бид бол Бурхан, Тэнгэрлэг Эцэгийн охид, хөвгүүд бөгөөд Тэрбээр биднийг хайрладаг мөн бидэнд юу хэрэгтэй байгааг мэддэг билээ. Тэрээр биднийг өөр хэнд ч биш харин Түүнд хандан залбирч, Түүнтэй харилцаж байгаасай хэмээн хүсдэг. Бидний Их Эзэн Есүс Христ “га нар миний нэрээр Эцэгт үргэлж залбирах ёстой” хэмээн бидэнд заасан билээ.¹ Залбирлаар дамжуулан Түүнд хүрэх нь бидний амьдралын хэвшил болох үед бид Тэнгэрлэг Эцэгээ илүү сайн мэдэж авах бөгөөд Түүнд улам бүр ойртох болно. Бидний хүслүүд Түүнийхтэй илүү нийцэх болно.

Номлогчид анх надад Тэнгэрлэг Эцэгтэй хэрхэн харилцахыг зааж байхдаа залбирах дөрвөн алхмын талаар заасныг би санадаг юм. Тэр үед залбирлын талаар эдгээр 4 алхмаас өөргүн гүнзгий ойлголт авсан зүйл надад байгаагүй юм. Тиймээс, миний ихэнх залбирлууд утсаа залган хүнсээ захиалж хаягаа хэлээд, тасалж байгаа юм шиг² эсвэл “зөвхөн аюул тохиолдоход л тусламж гуйн” яаралтай тусламж хэрэгтэй үед Бурханыг [надад] туслах засварчин эсвэл үйлчилгээний ажилтан

мэтээр боддог байсан.”³ Би судрууд болон сүмийн удирдагчдын сургаалуудаас илүү ихээр суралцан, сүмд өсөхдөө залбирлаар дамжуулан Бурхантай харилцахдаа ямар байх ёстойг илүү сайн ойлгож авсан юм.

Ерөнхийлөгч Хинкли “Бид залбирч байгаа зүйлийнхээ талаар эргэцүүлэн бодож, тунгаан бяслаж, дараа нь нэг хүн нөгөөтэйгөө ярьж буй мэтээр Их Эзэнтэй ярих хэрэгтэй”⁴ гэж заажээ. Түүнчлэн Ерөнхийлөгч Хантэр “Бид бүхий л тусламжууддаа бүтэлгүйтэж, цөхрөн улмаар тусламж хэрэгтэй болсон тэр үедээ бус харин өдөр шөнийн алинд ч Бүхний Дээд Түүнийг санадаг байх хэрэгтэй”⁵ гэж заажээ. “Залбирахдаа зүрх сэтгэлийнхээ үнэн хүслээр бус аваас, энэ нь түүнд ямар ч ашиггүй, учир нь Бурхан тийм нэгийг ч хүлээн авдаггүй”⁶ гэж бошиглогч Мормон мөн сэрэмжлүүлсэн юм. Утга учиртай залбирахын тулд бид даруу байж, чин сэтгэлээсээ мөн “зүрхнийхээ бүхий л эрч хүчээр”⁷ залбирах ёстой. Мөн бид залбирч байхдаа “хоосон давталтуудаас”⁸ зайлсхийхийн тулд сэрэмжтэй байх ёстойг Аврагчаас сурдаг.



Бид хийж байгаа бүх зүйлдээ Тэнгэрлэг Эцэгийн удирдамж болон хүч чадлыг эрэлхийлэхдээ Алма өөрийн хүү Хиламанд өгсөн зөвлөгөөг бидэнд өгсөн сайн зөвлөгөө хэмээн хүлээн авах хэрэгтэй. “Тиймээ, мөн өөрт хэрэгтэй бүхий л дэмжлэгийн төлөө Бурханаас гуй; тиймээ, бүхий л үйлүүд тань Их Эзэний төлөө байг, мөн чи хаана ч явсан Их Эзэнтэй нэгдмэл юм; тиймээ, бүх бодол санаа чинь Их Эзэнд чиглэсэн байг; тиймээ, зүрх сэтгэлийн тань хайр Их Эзэн дээр үүрд байрлаг. Бүх үйлүүдээ Их Эзэнтэй

Далын Ахлагч
Сиү Хонг Пон

зөвлөгтүн, мөн тэрээр чамайг сайны төлөө чиглүүлэх болно; тиймээ, чи үдэш унтахаар хэвтэхдээ, тэрээр нойронд чинь чамайг манаж болохын тулд Их Эзэний төлөө хэвт; мөн өглөө босохдоо зүрх сэтгэл чинь Бурханд хандах талархлаар дүүрэн байг; мөн хэрэв чи эдгээр зүйлийг хийх аваас эцсийн өдөр өргөгдөх болно.”⁹

Тэнгэрлэг Эцэг биднээс зөвхөн адислалууд гуйхаас ч илүүг хийгээсэй хэмээн хүсдэг. Тэр ихэвчлэн бидэнд хариулт өгөхөөсөө өмнө “үүнийг оюундаа тунгаан бодох ёстой”¹⁰ хэмээн шаарддаг. Бид удирдамж хүлээн авахын төлөө залбирахад Тэр биднээс Ариун Сүнсний шивнээг хүлээн авахуйц зохистой байгаасай хэмээн хүсдэг. Хэрэв бид өөрсдийн болон бусдын сайн сайхны төлөө залбирч байгаа бол “хэрэв бид гачигдсаныг, мөн нүцгэрснийг хоосон буцааж, мөн өвдсөн хийгээд зовсонд үл очин, мөн хэрэв бидэнд буй аваас хөрөнгөнөөсөө гачигдсан тэдэнтэй эс хуваалцвал”¹¹ бидний залбирал хоосон байх болно. Тэнгэрлэг Эцэг бидний бүхий л зөв шударга хичээл зүтгэлд маань туслах хэдий ч бидний өөрсдөө хийж чадах зүйлүүдэд Тэр бараг тусалдаггүй.

Ерөнхийлөгч Жэймс Э.Фауст: “бид өвдөг сөгдөн олон залбирал хэлдэг” гэвч зүрх сэтгэлийн нам гүм залбирлууд ч тэнгэрт хүрдэг. “Залбирал бол үгээр хэлж эсвэл илэрхийлэхийн аргагүй бодгалийн чин сэтгэлийн хүсэл” гэж бид дуулдаг.”¹²

Иеремиа бидэнд бүхий л зүрх, сэтгэлээрээ залбирахыг зөвлөдөг.¹³ Инос өөрийнх нь бодгаль өлсөж, бүхэл өдрийн турш залбирснаа бидэнтэй хуваалцдаг.¹⁴ Залбирлууд хүч чадлаараа өөр өөр байдаг. Аврагч зовж шаналж байхдаа “маш шаргуу залбирч байлаа.”¹⁵ “Залбирлаар дамжуулан эрэлхийлдэг адислалууд нь заримдаа биднийг өөрсдийнхөө чадахыг хийж, хичээл зүтгэл гарган, шаргуу байхыг” шаарддаг.

“Жишээ нь, мацаг барих нь ихэнхдээ бидний зүрх сэтгэлийн зохих ёсны хүчтэй нотолгоо болдог. Алма Зарахемлагийн хүмүүст “би өөрөө эдгээр зүйлийг мэдэж болохын тулд олон хоног мацаг барьж бас залбирсан. Мөн эдүгээ би өөрөө тэдгээр нь үнэнийг мэднэ; учир нь Их Эзэн Бурхан өөрийн Ариун Сүнсээр надад тэдгээрийг үзүүлсэн юм”¹⁶ хэмээн гэрчилсэн. Бид мацаг барьснаар бодгалиудаа¹⁷ даруусгадаг ба энэ нь биднийг Бурханд болон Түүний ариун зорилгуудад илүү ойр авчирдаг”¹⁸ хэмээн заажээ.

Залбирал бол хоёр талт харилцаа юм. Залбирлаа төгсгөхдөө бид түр хүлээж, сонсох цаг гаргах хэрэгтэй. Энэ мөч нь биднийг сөгдөн суух үед Тэнгэрлэг Эцэг бидэнд зөвлөж, удирдаж, тайтгаруулахад шаардлагатай байдаг. Түүний хариултууд ихэнхдээ Ариун Сүнсний намуун зөөлөн дуу хоолойгоор эсвэл бидний нөхцөл байдлаас хамааран эргэн тойронд байгаа хүмүүсийн

сайхан сэтгэлийн үйлдлээр ирж болно.

Бид заримдаа Тэнгэрлэг Эцэгтэй ярилцах зохистой биш гэж мэдэрч болно. Нифай бидэнд “Учир нь хэрэв та нар хүмүүнд залбирахыг сургах Сүнсийг анхаарах аваас, та нар залбирах ёстойг мэдэх бөлгөө; өөрөөр хэлбэл хилэнцэт сүнс хүнд залбирахыг үл сургана, харин тэрээр залбирах ёсгүйг түүнд сургадаг”¹⁹ хэмээн заасан. Сатан үргэлж биднийг залбирах ёсгүй хэмээн үнэмшүүлж мөн уруу татахыг хүсдэг. Гэсэн хэдий ч Аврагч бидэнд “ялан дийлэгч болж гарахын тул чи ямагт залбир; тиймээ, чи Сатаныг ялж гарахын тулд, мөн түүний ажлыг дэмжиж байдаг Сатаны зарц нарын гараас зугтаахын тулд буюу”²⁰ хэмээн заасан. Бид хаана байгаагаасаа үл хамааран “зүрх сэтгэлээ дүүрэн байлгаж, залбирлаа [Бурханд] тогтмол хандуулж байх хэрэгтэй”²¹. Бид Эцэгтэй дотроо чимээгүйхэн талархал илэрхийлж, үүрэг хариуцлагуудад маань биднийг хүчирхэгжүүлж, уруу таталтууд эсвэл бие махбодын аюултай мөчид бидэнд туслахыг Түүнээс гуйж болно.

Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцах бидний харилцааны суваг үргэлж нээлттэй байдгийг би гэрчилж байна. Дэлхийн ямар ч эрх мэдэл Тэнгэрлэг Эцэгтэйгээ шууд харилцахад бидэнд саад болж эсвэл зогсоож чадахгүй. Биднийг залбирах үед техникийн эсвэл цахилгааны ямар ч асуудлууд гарч чадахгүй. Бид өдөрт хэдэн удаа эсвэл хэр удаан залбирахад ямар нэгэн хязгаарлалт

байхгүй. Залбирал болгондоо хүсэх эсвэл залбирах хэрэгцээнд ямар нэгэн хязгаарласан тоо байхгүй. Ямар ч цагт мөн хаана ч байсан Түүнд хүрэх боломжтой. Бид Түүнтэй үл харилцахыг сонгосон үед эсвэл бид нүгэл үйлдэж, Ариун Сүнсний шивнээг хүлээн авах боломжгүй болсон үед л Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцах харилцааны сувагт саад учрах болно. Наманчлал бол Тэнгэрлэг Эцэгтэй харилцах бидний харилцаан дахь саадыг авч хаях цорын ганц арга зам юм. Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай бөгөөд Тэр Өөрийн хүүхдүүдтэйгээ харилцах дуртай гэдгийг Есүс Христийн нэрээр гэрчилж байна, Амен. ■

NOTES

1. 3 Нифай 18:19.
2. *Teachings of Gordon B. Hinckley* (1997), 469-ийг үзнэ үү.
3. Ховард В.Хантэр, *The Teachings of Howard W. Hunter*, ed. Clyde J. Williams [1997], 39-ийг үзнэ үү.
4. *Teachings of Gordon B. Hinckley* (1997), 469.
5. Ховард В.Хантэр, *The Teachings of Howard W. Hunter*, ed. Clyde J. Williams [1997], 39.
6. Моронай 7:9.
7. Моронай 7:48.
8. Матай 6:7-г үзнэ үү.
9. Алма 37:36-37; мөн Алма 34:17-26-г үзнэ үү.
10. Сургаал ба Гэрээ 9:7-8-ыг үзнэ үү.
11. Алма 34:27-29-ийг үзнэ үү.
12. "Prayer Is the Soul's Sincere Desire," Сүмийн дуулал, дугаар. 145.
13. Иеремиа 29:13-ыг үзнэ үү.
14. Инос 1:4-ийг үзнэ үү.
15. Лук 22:44.
16. Алма 5:46.
17. Дуулал 35:13-ыг үзнэ үү.
18. Жэймс Э.Фауст, "The Lifeline of Prayer," *Ensign*, 2002 оны 5-р сар, 60; lds.org/general-conference/2002/04/the-life-of-prayer?
19. 2 Нифай 32:8.
20. Сургаал ба Гэрээ 10:5.
21. Алма 34:27; мөн 3 Нифай 20:1-ийг үзнэ үү.

Орон нутгийн мэдээний редакторын туслах Э. Намуун

Хаана ч дуудсан бид үйлчлэх болно

"Та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа гэдгээ мэдээж болохын тулд буюу" (Мозая 2:17).

Их Эзэн Монгол орныг адисласнаар бид Христийн сайн мэдээг хүлээн авах боломжтой болсон төдийгүй Түүний залуу, ахмад олон номлогч Монгол оронд маань үйлчилсээр байна. Тэдгээр номлогчдын агуу ажлын үр дүнд олон хүн Түүний сургаалд хөрвөгдөн, өөрсдийн амьдралд асар их адислалыг хүлээн авсаар байна. Одоо Монгол Улаанбаатар номлолд 80 гаруй залуу, 10 хос ахмад номлогч үйлчиж байна.

Монгол Улаанбаатар Номлолын Ерөнхийлөгч Бенсон ба түүний гэр бүл



Ерөнхийлөгч Бенсоны гэр бүл

2013 оны 7 сард Монголын Номлол нэгэн онцгой залуухан ерөнхийлөгчтэй болсон билээ. Бенсон ах болон түүний эхнэр Монгол хэлээр маш сайн ярьж, ойлгодог бөгөөд энэ нь бидэнд Бурханаас илгээсэн онцгой адислал боллоо.

Ахлагч Бенсон 1996 оны 6-р сард анх Монголд ирж, Монгол Улаанбаатар номлолд үйлчилсэн анхны бүрэн цагийн залуу номлогчдын нэг юм. Харин Хэйди Бенсон эгч 1999-2001 оны хооронд Монголд үйлчилжээ. Тэд 2002 онд Логаны Ариун сүмд гэрлэсэн ба одоо дөрвөн хүүхэдтэй. Бенсон ах физикч, хуульч мэргэжилтэй бөгөөд хууль зүйн ухааны доктор юм.

Ерөнхийлөгч Бенсон хэзээ нэгэн цагт ахмад номлогчоор Монголд дахин үйлчилнэ гэж бодож байсан ч, ийм залуу байхдаа үйлчилнэ гэж төсөөлөөгүй аж. Нэгэн өдөр Тэргүүн Зөвлөлийн 1-р зөвлөх Хэнри Б. Айринг ах түүн рүү залгаад Монголд номлолын ерөнхийлөгчөөр үйлчлэх үү гэж асуужээ. Энэ нь түүнд онцгой санагдсан төдийгүй Бурханы ажил учраас тэд баяртайгаар хүлээн авчээ.

Номлолын ерөнхийлөгч гэдэг өндөр хариуцлагатай ажил бөгөөд тэрээр өөрийн эхний үүрэг хариуцлагыг гэр бүлээ хайрлан, халамжлах гэж үздэг. Удаах нь Монголд үйлчилж буй бүх номлогчийг хариуцан ажиллах мөн УБ Зүүн дүүрэг, Дархан дүүрэг, Номлолын 5 салбарыг хариуцан ажиллахаас гадна сүмийн гишүүн бүрд үлгэр жишээ болж тэдэнд зааж сургах явдал. Номлолын ерөнхийлөгч нь хувь хүмүүс рүү илүү чиглэн ажилладаг бөгөөд тэднийг Есүс Христийн сайн мэдээнд урьдаг.

Ерөнхийлөгч Бенсон Монгол орон өсөн дэвжиж, Ариун сүмтэй болоосой гэж хүсдэг. Тэр сүмийн нийт гишүүдэдээ: “Монголд Ариун сүмтэй болохын тулд гишүүд өөрсдөө Есүс Христийн сургаалийн дагуу маш хичээнгүй амьдрах хэрэгтэй. Тэд сүмд ирж, бусдыг хайрлан бусдад үйлчлэх хэрэгтэй. Яг л Есүс Христ шиг бусдад тусалж, тэднийг хайрлах хэрэгтэй. Мөн сүмийн гишүүд хүлээн авсан дуудлагаа илүү сайн гүйцэтгэх хэрэгтэй. Бурханаас өгсөн дуудлагыг эрхэмлэн биелүүлээс ариун сүмийн үүрэг хариуцлагыг хүлээн авахад бэлтгэгдэх болно” хэмээн хэллээ.

Ахлагч Гросбек ба систер Гросбек

Гросбек эгч ах хоёр Бригам Янгийн Их Сургуульд анх учирчээ. Тэд 1980 онд Айдохогийн Фаллс Ариун сүмд гэрлэсэн бөгөөд өдгөө гурван хүүхэд, 8 ач зээтэй юм.

Гросбек эгч Японы Саппород, Гросбек ах Америкийн баруун мужид бүрэн цагийн номлолд үйлчилсэн байна. Тэд 33-н жилийн өмнөөс ахмад номлогчоор үйлчлэхээр шийдсэн аж. Их Эзэн тэднийг хаана үйлчлүүлэхийг хүссэн тэр газар үйлчлэхэд бэлэн байв.

Тэд 2012 оны 6-р сард Монголд ирсэн бөгөөд 2014 оны долоон сард номлолоо дуусгах юм. Тэд Мөрөн салбарт 6 сар сүмийн удирдагчдад туслахаар мөн Чойбалсан салбарт 5 сар, Ховд



**Ахлагч
Гросбек,
систер
Гросбек**

салбарт 2 сар тус тус үйлчилжээ. Одоо тэд Эрдэнэт салбарт үйлчилж байна.

Гросбек ах, эгч хоёр мөн Англи хэлний хичээлийг дунд сургууль, оюутан залуус, багш нар, сүмийн гишүүд, удирдагчид, хөгжлийн бэрхшээлтэй өсвөр насныхан, залуу насанд хүрэгчид, эмч нарт заасан юм.

“Бид сайн мэдээ үнэн гэдгийг мэднэ. Мөн Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан сэргээгдсэн Тэнгэрлэг Эцэгийн агуу төлөвлөгөө болон Аврагчийн Цагаатгалыг дэлхий ойлгосноор адислагдах болно гэдгийг бид мэднэ. Эдгээр зүйлс бол бидний амьдралд утга учир өгдөг бөгөөд Есүс Христ болон Бурханы талаар хуваалцсанаар мөнхийн боломжоо олж харахад тусална. Бурхан амьд бөгөөд Есүс бол бидний Аврагч, бидний төлөө нас барж мөн дахин амилснаар бидэнд наманчилж, Түүнд болон Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очих замыг бэлдсэн. Мормоны Ном бол Бурханы үг. Үүний заавраар амьдарснаар бид Тэнгэр дэх гэртээ буцаж очих боломжийг олдог. Санваарын хүч ба Ариун сүмийн ёслолоор дамжин бидний гэр бүл мөнхөд хамт байж чадна. Есүс Христийн нэрээр Амен” хэмээн тэрээр гэрчилсэн юм.

Ахлагч Гарднэр ба систер Гарднэр

Ахлагч Гарднэр болон түүний эхнэр Америкийн Юта мужаас 2012 оны 10-р сард Монголд ирсэн бөгөөд 2014 оны 4-р сард тэдний номлол дуусах юм. Гарднэр ах эгч хоёр 1965 оны 6-р сард Солт Лэйкийн Ариун сүмд мөнхөд холбуулжээ. Одоо тэд таван хүүхэд, 11 ач зээтэй сайхан гэр бүл.

Монгол Улаанбаатар номлол тэдний 3 дахь

номлол. Тэд өмнө нь Камбодиа болон Хонг Конгийн Ариун сүмд үйлчилж байжээ. Тэд Ерөнхийлөгч Томас С.Монсон ахаас Монголд үйлчлэхээр дуудсан захидал хүлээн аваад ихэд гайхаж мөн баярласан байна. Гарднэр ах эгч хоёр олон жилийн өмнө залуу номлогчоор үйлчилж байсан төдийгүй одоо ч Бурханы ажлыг дуулгавартайгаар үргэлжлүүлсээр байна.

Ахмад номлогчийн хувьд тэдний үндсэн үүрэг хариуцлага бол онцгой тусламж хэрэгтэй байгаа хүмүүсийг халамжлан тэдэнд туслах юм. Ахлагч Гарднэр гишүүд болон удирдагчдад халамжийн зарчмуудын талаар заадаг. Халамжийн зарчим нь Сүмийн мацгийн өргөлийн санг хэрхэн хэрэглэх мөн мацгийн өргөлөө хэрхэн төлөх зэргийг багтаадаг. “Их Эзэний замаар хангах нь” хэмээх сүмийн гарын авлагаас тэд удирдагчид болон гишүүдэд заахыг хичээдэг. Мөн тэд англи хэл заах америк номлогчдын хуваарийг зохицуулахын зэрэгцээ ахлагч Гарднэр “Донтолтоос ангижрах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд тусалдаг бөгөөд Номлолын Ерөнхийлөгчийн зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дуудлагатай. Тэд англи хэлний хичээл заадаг.

Ахлагч Гарднэр: “Хэдхэн богинохон үгээр Есүс Христийн сайн мэдээний талаарх өөрийн гэрчлэлээ илэрхийлнэ гэдэг хэцүү юм. Бид Их Эзэн болон Есүс Христийн сайн мэдээнд хайртай. Бид Аврагчийн Цагаатгал бодит гэдгийг мөн түүний зарлигуудыг дагаснаар адислагдана гэдгийг мэднэ. Бид судруудад ялангуяа Мормоны Номонд хайртай. Тэнгэрлэг Эцэг амьд мөн биднийг хайрладаг” хэмээх өөрийн гэрчлэлийг бидэнтэй хуваалцаж байна.



**Ахлагч
Гарднэр,
систер
Гарднэр**

Ахлагч Линфорд ба систер Линфорд



**Ахлагч
Линфорд,
систер
Линфорд**

Линфорд ах эгч хоёр Юта юужийн Солт Лэйкээс зүүн тийш 90 км орчимд байдаг Мидвэй гэдэг жижиг хотоос ирсэн. Тэд гэрлээд 41 жил болж байгаа бөгөөд 5 хүүхэд 18 ач зээтэй. 2001 онд Линфорд ах эгч хоёр Германы Франкфуртын номлолд байх үедээ ургийн бичгийн богино хэмжээний киноны төвд ажиллан кинонуудыг Европ даяар түгээж үйлчилдэг байжээ. 18 сарын турш Германд үйлчилснийхээ дараа тэд Ариун сүмийн номлогчоор гурван сар үйлчилсэн байна.

Тэд дахиад номлолд үйлчлэхээр шийдсэний дараа тэдний дараагийн номлол нь Монгол Улаанбаатар номлол гэдгийг сонсоод ихэд баярлаж байжээ. Линфорд ах эгч хоёр 2013 оны 8 сарын 16-нд Монголд ирсэн бөгөөд 2015 оны 2-р сард тэдний номлолын хугацаа дуусах юм. Тэдний номлолын томилгоо бол Ганц бие залуу насанд хүрэгчидтэй хамтран ажиллаж, тэдэнд тусалж, дэмжих үүрэгтэй юм. Залуучууд бол сүмийн ирээдүйн гэрэл бөгөөд тэдэнд үйлчлэх нь онцгой боломж билээ. Тэдний сүнслэг хүч болон гэрчлэлүүд нь тэдэнд сүнслэг өдөөлт болоод зогсохгүй тэднийг улам хүчирхэгжүүлсээр байдаг билээ.

Ахлагч Линфорд, систер Линфорд: “Есүс Христийн сайн мэдээний талаарх бидний гэрчлэл бол энэ ажил бол үнэхээр ‘гайхамшиг мөн гайхал бахдалын ажил’. Мормоны Ном бол биднийг Христэд улам ойр авчирдаг судар юм. Бидэнд сүнслэгээр нөлөөлж удирдах амьд бошиглогчид болон төлөөлөгчдөөр бид маш их адислагдсан. Бид энэ гайхамшигт ажилд тусалснаар бидний зүрх сэтгэл улам даруусгагддаг билээ” хэмээн өөрсдийн гэрчлэлийг даруухнаар хуваалцсан юм.

Ахлагч Стюарт ба систер Стюарт



Стюарт ах эгч хоёр 1968 оны 8 сарын 22 нд Канадын Кардстон Альберта ариун сүмд гэрлэжээ. Тэд дөрвөн хүү нэг охинтой бөгөөд 15 ач, зээтэй билээ. Тэд 2012 оны 10 сард Монголд ирсэн бөгөөд 2014 оны дөрвөн сард номлолоо дуусгах аж.

Тэд хүмүүст туслахыг хүссэн учраас номлолд гарчээ. Номлолын төв тэдэнд Монгол Улаанбаатар номлолыг санал болгосон бөгөөд энэ нь тэдний хувьд төгс тохирсон газар байсан юм. Тэдний хүүхдүүд бүгд бүрэн цагийн номлолд үйлчилжээ. Одоо тэдний ач зээ нар нь номлолдоо гарч, Бурханы сургаалыг түгээхээр явж байгаа аж. Энэ нь Стюарт ах эгч хоёрыг номлолд үйлчлэхэд нь урам зоригийг өгчээ.

Ахлагч Стюарт 41 жилийн турш гэр бүлийн эмчээр ажилласан. Түүний эхнэр нийгмийн эрүүл ахуйн чиглэлээр ажиллаж байжээ.

Тэдний номлолын үүрэг хариуцлага бол Ариун сүмийн аялалыг зохион байгуулах бөгөөд Стюарт ах номлолын эмчээр үйлчилж байна. Бүрэн цагийн номлолд үйлчилж буй номлогчдод эмнэлгийн тусламж мөн хэрэгтэй зөвлөгөөг өгдөг. Мөн ЭМШУИС-ийн оюутнуудад англи хэлний хичээл заадаг.

“Эмээ маань хамгийн анхны гар тэрэгний аялалд явж байсан. Түүний итгэлийн өв нь бидэнд их нөлөөлсөн. Эмээ маань бидэнд агуу шийдвэр төгс байдлыг харуулсан юм. Бид бүгд шийдвэр төгс байж чадвал бүх зүйлийг хийж чадна. Бид нэлээд хэдэн жилийн өмнө хоёр сайхан хүүгээ уулын ослоор алдсан юм. Тэнгэрлэг Эцэг загалмай дээр Хүүгээ алдсан. Цагаатгал бол үнэхээр гайхалтай. Христийн нэрээр, амен”.

*Ахлагч Стюарт,
систер Стюарт*

Ахлагч Фармер, систер Фармер

Фармер ах эгч хоёр 2012 оны 7-р сард Монголд ирсэн. 2014 оны 3-р сард номлолоо дуусгах ажээ. Тэд 1966 оны 6-р сарын 24-нд Калифорнийн Оукландын ариун сүмд гэрлэжээ. Фармер ах эгч хоёр сэтгэл судлаач, гэр бүлийн түүхийн зөвлөх мэргэжлээр 30 гаруй жил гэр бүлүүдтэй хамтран ажиллаж ирсэн арвин туршлагатай хүмүүс. Тэд гэрлээд 40 гаруй жил болж байгаа бөгөөд 7 хүүхэд 26 ач зээтэй өнөр гэр бүл билээ.

Тэд маш олон жилийн өмнөөс номлолд үйлчлэхээр шийдсэн ба Оросын холбооны улсад үйлчилнэ хэмээн төлөвлөж байжээ. Учир нь Фармер эгч орос хэлийг сайтар эзэмшсэн юм. Тэд анх номлолд үйлчлэх хүсэлтээ Номлолын төвд илгээхэд Монгол орныг санал болгосон төдийгүй Гэр бүлийн түүхийн номлогчид хэрэгтэй байгаа гэдгийг тэдэнд дуулгасан юм. Тэдний охин 1998-2000 онд Монгол Улаанбаатар номлолд үйлчилсэн нь тэдэнд гайхалтай үлгэр жишээ болжээ.

Монголын бүх хөдөө орон нутаг болон 12 салбар, тойргийн удирдагч болон гишүүдэд ургийн бичиг ба гэр бүлийн түүхээ хэрхэн хөтлөхийг зааж сургадаг. Мөн Азийн гэр бүлийн түүхийн зөвлөхүүдтэй хамтарч ажилладаг билээ. Тэд Монголын үндэсний архивын төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан нь гишүүд өвөг дээдсийнхээ талаар мэдээллийг олж авах боломжийг нээлттэй болгосон юм.

*Ахлагч Фармер,
систер Фармер*



Ахлагч Нэй, систер Нэй

Ахлагч Нэй, систер Нэй нар маань Америкийн Юта мужийн Бригэм хотоос 2013 оны 6-р сарын сүүлээр Монголд ирсэн юм. Тэд 1974 оны 3-р

сарын 20-нд Солт Лэйкийн ариун сүмд гэрлэсэн бөгөөд 6 хүүхэд, 18 ач, зээтэй өнөр өтгөн гэр бүл. Ахлагч Нэй ажиллахаа больсныхоо дараа анх номлолд үйлчлэхээр шийджээ. Бурханаас тэдэнд бэлдсэн гайхалтай зүйл бий гэдгийг ахлагч Нэй мэдэрч байжээ. Энэ бол тэдний номлол байсан юм. Тэд Монгол Улаанбаатар номлолд хүмүүнлэгийн чиглэлээр Дэээрэт Олон улсын Энэрлийн байгууллагад үйлчилж байна.

Тэдний үйлчилж буй Дэээрэт Олон Улсын Энэрлийн байгууллага нь хүмүүсийг зовлонгоос хөнгөвчлөх, бие дааж амьдрах чадварыг урамшуулан дэмжиж туслах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг дэмжих мөн гэр бүлийг бэхжүүлэх зорилготой. ДОУЭБ нь нярайн эндэгдлийг бууруулах, хэрэгцээтэй хүмүүсийг тэргэнцрээр хангах, цэвэр усны хангамж, хүнсний үйлдвэрлэлийг дэмжих, хараа зүй болон эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх гэсэн үндсэн таван чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд амьдралын түвшин доогуур, өрхийн орлого багатай гэр бүлийн хүүхдүүдэд боловсрол олгоход тусалдаг.

Ахлагч Нэй хэлэхдээ, “ЕХХҮТС бол Их Эзний үнэн сүм гэдгийг мэднэ. Бид өөрсдийн Аврагч Есүс Христэд хайртай. Мөн Тэр бидний Аврагч, Гэтэлгэгч гэдгийг мэднэ. Түүний Цагаатгал болон наманчлалаар дамжуулан өсөж дэвжиж, Түүнтэй илүү адилхан болох боломжтой байдагтаа талархалтай байдаг. Мормоны Ном бол Бурханы үг гэдгийг мэднэ. Үүнийг унших болгондоо Түүний хайрыг илүү ихээр мэдэрдэг. Томас С.Монсон бол Бурханы Бошиглогч гэдгийг мэднэ” хэмээн гэрчилжээ.



**Ахлагч Нэй,
систер Нэй**

Ахлагч Ингланд, систер Ингланд



**Ахлагч
Ингланд,
систер Ингланд**

Ахлагч Ингланд болон түүний гэргий Америкийн Юта мужийн Оаклэй гэдэг газраас 2013 оны 1-р сард Монголд ирсэн бөгөөд 2014 оны 6-р сард номлолоо дуусгах аж. Тэд 1979 оны 12 сарын 27-нд Солт Лэйкийн ариун сүмд гэрлэсэн ба одоо 3 хүүхэд 5 ач, зээтэй. Тэд залуу байхаасаа л номлолд явахыг, түүгээр ч барахгүй хүмүүнлэгийн чиглэлээр үйлчлэхийг хүсч байсан бөгөөд номлолын төв тэдэнд Монгол Улаанбаатар номлолыг санал болгожээ.

Ингланд ах эгч хоёр Монголын Тасралтгүй Боловсролын сан болон Ажил олгох төвд үйлчлэхийн зэрэгцээ Хавай дахь БЯИС-ийн Мичиганы тестийн шалгалт, мөн Монголд үйлчлээд буусан номлогчдод номлолын дараах боловсрол болон ажил олох сургалтыг зохион байгуулдаг. Ахлагч Ингланд Налайх салбарын 2-р зөвлөхөөр үйлчилдэг ба Ганц бие залуу насанд хүрэгчидтэй хамтран ажилладаг.

Тэрээр “Бид Бурхан Есүс Христ амьд гэдгийг мэднэ. Тэд бидний залбирлыг сонсож хариулдаг. Миний гэр бүл болон Есүс Христийн Цагаатгал нь бидний утга учир юм. Бид бошиглогчдоос илчлэлт хүлээн авах боломжтой байгаадаа маш их талархалтай байдаг. Мөн Бурхан бидэнд бүх зүйлсийг өгдөг бөгөөд Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм байгаад маш их талархалтай байдаг” хэмээн гэрчиллээ.

Ахлагч Фрэдлэй ба систер Фрэдлэй

Ахлагч Фрэдлэй болон түүний эхнэр Америкийн Юта мужаас ирсэн бөгөөд тэд хоёул насанд хүрснийхээ дараа сүмд хөрвөгдсөн

ажээ. Ахлагч Фрэдлэй эхнэртээ анх сайн мэдээг танилцуулжээ. Тэд 1971 онд гэрлээд хоёр сарын дараа Фрэдлэй ах эхнэртээ баптисм хүртээсэн бөгөөд одоо тэд 4 хүүхэд 6 ач зээтэй ажээ. Тэд 2013 оны 6-р сард Монголд ирсэн бөгөөд ба 2 жилийн турш үйлчлэх юм.

Ахлагч Фрэдлэй арван жилийн өмнө хэзээ нэгэн цагт Монголд үйлчлэх болно гэсэн мэдрэмж хүлээн авч байсан гэдгийг онцгойлон хуваалцсан юм. Монгол Улаанбаатар номлол бол тэдний анхны номлол.

Ахлагч Фрэдлэй Дархан дүүргийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн 2-р зөвлөхөөр Фрэдлэй эгч Дархан дүүргийн Хүүхдийн хэсгийн 2-р зөвлөхөөр тус тус үйлчилдэг. Тэд мөн Өнчин хүүхдүүдийн асрамжийн газарт авьяаслаг, сурах хүсэл эрмэлзлээр дүүрэн 40 гаруй хүүхдэд англи хэлний хичээл заадаг. Мөн Дархан 1 ба 2-р салбарт англи хэлний хичээл зааж гишүүдийн боловсролд үнэтэй хувь нэмэр оруулж байна. Тэд мөн “Өдөр өнжүүлэх” төвд суралцдаг хүүхдүүдийн онцгой хэрэгцээнд нь тулгуурлан амьдрах ур чадварын хичээл заадаг юм.

Ахлагч Фрэдлэй “Бидэнд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан сэргээгдсэн Их Эзэний сүмийн талаар хүчтэй гэрчлэл бий. Мормоны ном нь Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очих мэдлэгийн эх сурвалж төдийгүй энэ илчлэгдсэн номон дахь зарлигуудыг дуулгавартай даган өдөр бүр залбирснаар бид Түүний гарт байж, сайн зүйлсийг хийхээр зааварлагдах болно гэдгийг мэднэ” хэмээх гэрчлэлээ хуваалцсан юм. ■



Ахлагч Фрэдлэй, систер Фрэдлэй

Сүмийн гишүүдийн гэрчлэлээс

“Семинарт явснаараа гэр бүл болон сүм мөн эргэн тойрныхоо хаана ч гэсэн Бурханы сайн охин байж чаддаг. Зохистой хувцаслаж, зөв үг хэллэг хэрэглэн, биеэ зөв авч явснаараа сатаны уруу таталтыг даван туулах хүч чадлыг Бурханаас авч чаддаг. Өглөө бүр эрт босож золиослол гарган асар том сонголтыг хийж байгаа нь Бурханы Сүнсийг өөртэйгөө илүү ойр байлгаж мөн селестиаал хаант улсад орох үүдээ бага багаар нээж байгаа хэрэг юм. Түүнчлэн би семинартаа идэвхтэй явж, судраа тогтмол уншиж байсны минь нэг том шагнал нь 2013 оны гар тэрэгний аялалын үед зохиогдсон АХА тэмцээнд 1-р байранд орж адислагдсан явдал юм. Энэ чуулган нь миний хувьд анхдагчдыг дурсан санаж мөн тэдний туулсан замын өчүүхэн хэсгийг ч гэсэн өөрийн биеэрээ амсачыг хичээснээрээ өвөрмөц байсан юм.”

.....
Шинэ Дархан салбарын залуу эмэгтэй Гантулгын Одонтуяа /16 настай/

“Би семинарт явснаар биеэ зөв авч явдаг төдийгүй юу хийх нь зөв, юу хийх нь буруу гэдгийг мэддэг болсон. Үүний ачаар хийх зүйл маань улам бүр

ойлгомжтой байдаг. Намайг мэргэн ухааны үгийг дагадаг болохоор миний найзууд хажууд хараал хэдэггүй, тамхи ч татахаа больсон. Зарим үед найзууд маань надаас зөвлөгөө авдаг. Би анх семинарт явсан жилээ английнхаа шилдэг сурагч болж мөн надад мэдэгдэхүйц өөрчлөлт гарахад аав, ээж минь семинар ямар чухал болохыг мэдэж семинарт явуулах дуртай болсон. 2013 оны гар тэрэгний аялалд явахад салбараасаа Пүрэвцогт бид хоёр л хөвгүүн бусад нь охид байсан. 2 өдөрт 32 км бартаатай замыг тэрэг түрэн туулах үед бусад салбарын зарим хөвгүүд тусалж байсан нь яг л Сион руу тэмүүлж буй гэгээнтнүүд гэлтэй. Ингэж аялахад уул, ус, жалга, дов, сондуулыг Бурханы хүчээр ядралгүй давсан бөгөөд хөгжилтэй байсан. Гар тэрэг маань хөнгөн мэт болж бартаатай замыг анзааралгүй амархан туулж байсан нь бид Бурханы адислал дор эвсэг байж зөвхөн өөрийгөө биш харин бусдыг гэсэн хайр дүүрэн сэтгэлтэй байсных билээ. Энэ нь миний хувьд бас нэг томоохон гэрчлэл минь болсон.”

.....
Шинэ Дархан салбарын залуу эрэгтэй Отгонжаргалын Цогбаяр /17 настай/ ■